



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/01

Чингис хот

**Цэргийн бүртгэл зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, аймгийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны Цэргийн бүртгэлийг зохион байгуулахад 1,377,500 (нэг сая гурван зуун далан долоон мянга таван зуун) төгрөгийг зарцуулсугай.
2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн бэлтгэл сургууль, цугларалт, зориулалтын бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2022 оныдугаар сарын өдрийн
.....дугаар тушаалын хавсралт

2022 ОНЫ ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙН ТӨСӨВ

д/д	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хянасан
1	Цэргийн бүртгэлийн явцтай танилцаж заавар, зөвлөмж өгч ажиллах 2 хэсэг болж ажиллах	210л АИ92 1050 км	2.350	493.500	
2	Батлан хамгаалах хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах хулдаасан хэвлэл хэвлүүлэх	2*2 хэмжээтэй 22ш	10.000	440.000	
3	Бичгийн цаас	2	10.000	20.000	
4	Томилолтын зардал	4 хүн / 4 хоног	26.500	424.000	
				1.377.500	